



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

[2021](#) оны [12](#) сарын [17](#) өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “бодлогыг батлах” гэснийг “бодлого” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.16 дахь заалтын “энэ хуулийн 5.1.4-т заасан хөтөлбөрийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх” гэснийг “харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх” гэж, 6<sup>1</sup> дүгээр зүйлийн 6<sup>1</sup>.6 дахь хэсгийн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20.2-т” гэснийг “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “үндэсний хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтын “стратеги” гэснийг, 6<sup>1</sup> дүгээр зүйлийн 6<sup>1</sup>.6 дахь хэсгийн “дөрвөн жилд нэг удаа” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР